

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лувсан	Дугаар	L027
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Баянгол дүүрэг
Төрсөн газар	Ховд аймаг	Төрсөн он	1913
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Ховд аймгийн Шар сүм, Хүрээний Дашчоймбол дацан	Сүм хийдийн дугаар	UBR 912,ХОХХ 076
Одоогийн сүм хийд	Гандантэгчинлэн хийд	Сүм хийдийн дугаар	UB 01
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 11-р сарын 8	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



Ховд аймгийн Ховд сумын Өөлдийн Шар сүм

Шар сүм Ховд аймгийн төвөөсөө хойш 2 км орчим зайтай байсан. Буянтын голоор зааглагддаг, урд тал нь Ховд хот, хойд талд нь Шар сүм. Шар сүм Монголын сүм биш байсан.

Манжийн эзэн хааны хөрөнгөөр бий болсон Манжийн хаанаас байгуулсан сүм байсан. Монголоор “Түгээмэл амаржуулагч”, 8 шар сүм гэж нэртэй байсан. 8 сүмтэй, дөрвөн дацантай байсан. Алтай, Хангайн сүм, Чойр, Дэмчиг гэсэн хоёр жижиг дуган Чогчэн, Авга, хоёр жижиг сахиусны дуган байсан. Лам нар тийм олон биш, цөөвтөр. Дээр үед эзэн хааны зарлигаар тамгатай 3 гэгээн Нарванчин гэгээн, Дилав хутагт, Жааханз гэгээнийг (Жалханз гэгээн) 3, 3 жилээр даа гэсэн юм байна лээ. Тэд байж байгаад хамгийн сүүлд 1921 онд Жалханз гэгээн байж байсан. Шар сүм 3 гэгээн дааж байсан сүм юм. Эзэн хааны сангаас хэрэглэдэг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Даашинхүүгийн пүүс гэж байсан. Энэ пүүснээс хамаг хөрөнгө мөнгөө гаргадаг байсан. 160 ламын хэрэглэл дааж байсан юм байна лээ. Сүл 80, Чанга 80 гэж. Ондoo лам нар суувал өөрийнхөө хөрөнгөөр суудаг байсан.

Манжаас тусгаар болсны дараа 2,3 хошууд эзгүй хоцорсон. Сүүлд нь ноёдууд нь Шар сүмийг эндээ авна гэж аваад өөр сумын 2, 3 хошууны лам суулгаж хүрээ болсон юм. Тэгээд монгол дэглэмтэй болсон. Намайг сууж байхад 200 ламтай байсан. Цогчин, Авга, Чойр, Дэмчиг гэсэн 4 дацантай байсан. Цогчинд өдөр тутмын хурал,

Авга дацанд өвөл хурдаг цагийн хурал байдаг түүнийг хурдаг байсан. Жинхэнэ хурдаг дацан нь Авга, Цогчин 2 байсан. Авга дацан нь 2 давхар. Дээрээ манжийн хааны сүлд тэмдэгтэй, дотроо их бурхантай тийм дуган байсан.

Манжийн хааны эзэмшилд байхдаа тэргүүн лам гэдэг түшаалтан байсан. Тэргүүн лам нь Жааханз байсан. 29 онд дайн өнгөрөөд Жааханзыг нааш орж ирэхэд нэг ламыг тэргүүн болгосон юм гэсэн. Данзан тэргүүн гэж байсан. Тэгээд сүүлд нь Монголчуудын мэдэлд очоод тэргүүн гэдгээ болиод хамбатай, цоржтой болсон. Хийдийн ловон лам нь Осор, Соном-Осор гэсэн хүмүүс байсан. Жалцав, Сандагцэрэн, Цогтой, Довдон гэсэн 4 унзад байсан. Эхлээд Эрдэнэбүрэн, Мянгат хоёроос, сүүлд нь Буянт сумын Зуутын хүрээ, Чандманий хүрээ, Цагаан голын хүрээ, Думьяагийн хүрээ гэсэн 4 жижиг хүрээний лам нараас татаж суулгасан. Хуучин үедээ их дэглэмтэй, их сайхан цам гардаг тийм хийд байсан.

Сүмийн гол шүтээн нь Гомбо, Чойжоо, Лхам 3 байсан. Шүтээнийх гэсэн 3 жижиг дугантай. Гол ядам нь Жигжид. Хойд ууланд их сайхан бурхан байсан. Бурхан багшийн баримал 2 шавьтайгаа. Тэр их гоё. Найдан Жүдэг гэж 18 бурхан байсан. Дандаа баримал. Их гоё хийцтэй. Эхлээд Зуу дуган гэдэг нэртэй байсан, дараа нь Авга дуган гэдэг болсон хойд дуган нь ханандаа 10 Хангалтай, Ганжуур, Данжууртай. Буянтаас очсон лам нар тэр хойд дуганд хүрж байсан.

Хийдэд Дамбийдоной хувилгаан, Лувсангончиг хувилгаан гэж 2 хувилгаан байсан. Энэ хувилгаад гүн ухааны номыг голчлон заадаг байсан. Уншлагыг гэрээрээ голдуу сурчихсан учраас. Гандангийн лам нар нутгаараа очихдоо мөн чойрын ном заана. Тэдгээр лам нар нь Дамбийдоной хувилгаан, Чогсом гэдэг лам, Гомбосүрэн гуай гэдэг лам, Сандагдорж гэдэг лам байсан.

Гэлэн сахилтай 100 гаруй лам байсан байх. Хайланд л лав 100 гаруй гэлэн сууж байсан. Жамъян, Соном-Очир гэдэг 2 лам календарь, лит хийдэг зурхайч нар байсан. Жамъян, Самбуу, Чүлтэм-Осор гэсэн эмч нар байсан.

Би Чойрын дацанд сууж байсан. Гүнчин ламын гомон игчаа хүртэл үзсэн. Энд ирээд ч Гомон ирчаанд хурсан. Чойрын сургалт голлодог байсан. 7,8 зиндаа байсан байх. Нэг нэг жил болоод өгсөөд л байна.

3 суварга байсан. 10м гаруй өндөр том суварга байсан. Жанчив Чодун буюу Бурхан багшийн суварга байсан. Ганц ламд хааяа нэг дарж авдаг Чойрын номны бар байсан.

Хурал номын талаар Жилийн хурал: Цогчэндээ өдөр тутмын цогчэн хурлаа хурна. Цагаан сараар Чонпрүлжона гэж 15 хоног хурна. Энэ 15 хоногт дандаа Бурхан багшийн магтаал хурна. Зуны эхэн сарын 15-нд

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Донжтой хурал гэж хурж байсан. Намар 7 хоног нэг хурал хурна. Зуны сүүл сарын 15-аас намрын дунд сарын шинийн 8 хүртэл хайлан 45 хоног хурна. Өвлийн сүүл сарын шинийн нэгэнд хоёр дацандаа Арван Хангал хурна. Майдар, цам сортой зэрэг гардаг байсан. Майдар хаврын эхэн сарын 15-нд эргэнэ. Майдар эргэхэд цам гардаг байсан. 14-нд нь сортой цамтай байсан. Ардууд их ирнэ. Ойрын хэдэн сумынхан ирнэ. Их гоё цамтай байсан. Ганжуур жилдээ нэг хүрээгээ тойроод эргэнэ. Бурхан багшийн дүйчэн өдрөөр Манла хурж байсан байх аа. Богд ламын дүйчэн өдрөөр хурдаг л байсан. Өөрсдөө нүгнээ сахидаггүй байсан. Хааяа нэг улсууд сахиулна.

Дом тавьдаг байсан. Гавжийн дамжаа хоёр удаа болоод тэгээд хаагдсан юм байх аа. Маарамбын, аграмбын дамжаа барихгүй. Манайд төвд лам нар байгаагүй. Хэд хэдэн лам төвд рүү явж сурч байсан юм байна лээ. Дарамбазар, Жамц гэсэн дам нар байсан. Голдуу хүрээнд л суудаг байсан юм байна лээ.

Дуганууд нь тус тусдаа хэрмэн хашаатай. Дуган нь Амарбаясгалант хийдтэй адилхан тийм дугантай байсан. Ганц Зуу дуган гэдэг нь л хоёр давхар. Орой дээр нь Манжийн хааны сүлд байсан. Алтадсан, луу ороолгосон гурван самбар л байсан. Төвд, Хятад, Монголоор бичсэн бичигтэй. Гол хаалгаар Сүмд ороход л Алтай гэдэг том баатар Хангай гэдэг баатрын хоёр том баримал байсан. Хүүхэд айхаар.

Ганцхан жастай байсан. Малтай байсан юм байх. Тусгай няравтай, мал хариулдаг айлтай байсан. Хийдэд ганц лүйжинч лам байсан. Хандмаа нар бол байгаагүй. Тэр үед хоёр идэхгүй хоосон хонохгүй байсан. Наймаа их байсан. Сүүлд нь Цагаан Оросын худалдаа ирсэн. Манжийн хааны үед лам нар аймаглан том, том хашаатай суудаг байсан гэсэн. Тэрийг би мэдэхгүй. Сүүлд нь тийм юм байгаагүй. лам нар ихэнх нь гэртэй. Хэдхэн байшинтай лам нар байсан. Хуучин лам нарын сууж байсан байшинг засаад орсон. Хүрээнийхээ хоёр талаар л суудаг байсан.

Шар сүм 1921 онд эзгүй хоцорсон. Хүрээнийхээс лам нар татаж суулгаад эхлээд Эрдэнэбүрэн, Мянгат хоёроос, сүүлд нь Бүянт сумын Зуутын хүрээ, Чандманий хүрээ, Цагаан голын хүрээ, Думьяагийн хүрээ гэсэн 4 жижиг хүрээний лам нарыг татаж ахиж хурсан юм. Тэрнээс өмнө Манжийн хааны захиргаан дор 170 жил болсон сүм юм.

1938 оны цагаан сар болоход л лам нар баригдаад дууссан. Тэгээд л тэр жилдээ буулгасан. Ном судруудыг нь хээр аваачаад түлсэн шиг байдаг юм. Дутуу шатсан бар энэ тэр хөдөөгүүр харагдаж л байсан. Ганжуурыг нь түлсэн юм шиг байдаг.

Дашчоймбэлд намайг ирэхэд 3000 гаруй ламтай байсан. Идгаа, Гунгаа, Дашчоймбэл гээд гурван том Чойрын дацанд олон мянган лам байсан. 13-р Далай лам таалал боллоо гээд төвдүүд хурал хуруулсан юм. Мөнгөн зоос барьсан. Барьсан эздээ тоолсон юм байгаа биз. 9800-д лам байна гэж хэлж байсан гэсэн. Зүүн хүрээнд 30 аймгийн 30 дуган байсан. Ганданд Жанрайсагтай зургаан дуган байсан. 1938 он хаврын сүүл сарын 15-ны шөнө Дашчоймбэлийг лацдаад, ломбодоод хаячихсан. Гунгаачойлинг 10-аад хоногийн дараа, Идгааг 15, 16 хоногийн дараа хаасан юм. Гурван дацанг сарын дотор л багтаасан юм. Лам нарыг 1936 оноос эхэлж бариад 1937 онд улам их болоод намар нь эхлээд хавар нь дууссан. Дашчоймбэлд 3000 орчим, Гунгаачойлинд 2000 орчим, Идгаад 1000 гаруй лам нийтдээ Ганданд 6000 орчим лам байсан байгаа юм. Гандангийн гудамж бүрт л

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

лацдаж ломбодчихсон хаалга байдаг байсан. Эзгүй хашаа байсныг Хорооныхон худалдаж аваад Хорооны харчуул ирж суусан юм. Гандангийн гурван дуганд чинь Орос цэргүүд сууж байсан юм. Үүдэн дээрээ буутай харуул манаатай байсан юм.

Би дацан хаагдахад хөдөө Ховдод очиж артельд орж ажиллаж байсан, мал ч маллаж л байсан. Хар болсны дараа надаас татвар нэхсэн. Би төлөөгүй. Тэгээд аймаг дээр очиж ажилласан. Гэр бүл, үр хүүхэдтэй болсон. 1972 онд Улаанбаатарт ирсэн. Тэгээд хуралд хурах гээд өргөдөл бичээд Чадраа зурхайд өгсөн. Тэр үед Засгийн газар мэддэг байсан юм. Зөвшөрөхгүй байна л гээд байсан. 1989 онд хамба Дамдинсүрэн гэж байсан. Засгийн газрын шашны зөвлөл татан буугдсан гэж байсан. Тэгээд 1990 он ч боллоо хуралд хурах хүн байвал хүр гээд тэгээд хурж эхэлсэн юм аа. 10-аад хүн өргөдөл өгөхөд ганц нэгийг нь оруулбал оруулна тийм байсан юм.

Барианы үеэр чинь хаа хамаагүй явахаас хүртэл айна. Намжил гэдэг лам байсан. Буянтогтох гэдэг лам байсан. Тэгсэн тэр хоёр баригдлаа. Алуулсангүй. Гараад ирсэн юм. Тэгсэн сүүлд нь сонсохноо хэрэггүй юмнаас баригдсан байсан. Буянтогтохын амбаарт хэдэн кг өөхөн тос байж. Энэ өөхөн тосоор яах нь вэ гэж асуусан. Хавар болж байна. Боов хийж идье гэж хэлжээ. Тэгсэн бариад явсан. Боов хийж идээд гадаад руу оргох гэж байсан гэж баривчилсан байгаа. Кросиноор дэн барьдаг байсан юм. Намжил тэрүүгээр нэг шил кросин аваад явж байсан гэрт нь хүн дагаж орж ирээд бариад явсан. Тэгсэн чи Дотоод яамыг түймэрдэх гэж кросин авч явсан чинь үнэн үү гэж асууж байсан гэсэн. Буянтогтох 10 кг өөхөн тосноос 10 жил авлаа гэж байсан. Үнэхээр 10 жилийн ял авсан. Гэхдээ 2,3 жил болоод гараад ирсэн.